



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/210

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан Хэнтий уулын аймаг байгуулагдсан түүхт 100 жилийн ойг угтаж Эзэн Чингис хааны өлгий нутаг тус аймагт Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг залж аялуулж, хүндэтгэл үзүүлэх, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг Өсвөр үе, хүүхэд залуучуудад таниулах тусгаар тогтнол, үндэсний эв нэгдэл, эрх чөлөө, эрх чөлөөний үнэ цэнийг ойлгуулах, эх орон, Монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах, эх оронч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг аялуулах, ёслолын жагсаал, арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа
Гишүүдэд:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
	Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, Хурандаа
	Ш.Цолмон	Шүүх шинжилгээний хэлтсийн дарга, Цагдаагийн дэд хурандаа
	П.Мөнхбаатар	Хилийн цэргийн 0287 дугаар ангийн захирагч, хурандаа
	М.Бат-Очир	Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн


2.

захирагч, Дэд хурандаа

2.Цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг залж аялуулах, хүндэтгэл үзүүлэх, ёслолын жагсаал, арга хэмжээний үйл ажиллагаанд зориулж Цагдаагийн газарт 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

3.Дээрх ажлын хэсгийн үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийн аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайханд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ